



П.ЭРДЭНЭБААТАР
ХСИС-ийн
Цагдаагийн
сургуулийн мөрдөх
албаны тэнхимийн
багш, цагдаагийн
дэд хурандаа

ХЭРЭГ МӨРДӨХ АЖИЛЛАГААГ ТҮҮВЭР ТӨЛӨВЛӨГӨӨ АШИГЛАЖ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

Товч утга: Мөрдөн байцаалтын ажиллагааны явцад түүвэр төлөвлөгөөг ашиглан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг нотлох, байцаалтын зорилтыг тодорхойлох, хэргийг богино хугацаанд шийдвэрлэх арга замыг тодорхойлох, үйл ажиллагааг оновчтой болгох, талаар авч үзсэн болно

Abstract: In this abstract, I have written about how to prove a suspect guilty, determine investigation purpose, and identify a shortcut to finding a solution to the crime, and to make investigation process run smoothly by using selection planning technique properly in the investigation period.

Түлхүүр үг: Төлөвлөгөө, түүвэр, товчлол, нотлох баримт, тактик, сэжиг, таамаглал, байцаалт, баримт бичиг,

Keywords: planning, selection, shortcuts, evidence, tactics, suspicion, hypothesis, questioning, documents,

Төлөвлөгөө нь үйл явцыг удирдан зохион байгуулж буй субъектын гаргасан шийдвэрийг тусгасан албан ёсны баримт бичиг юм¹.

Хүн ямар нэгэн ажлыг хийж бүтээхийн тулд хийх зүйлийнхээ талаар тодорхой мэдлэгтэй, эмх цэгцтэй, дэс дараалал, төлөвлөгөөтэй ажиллавал ажил шуурхай явагдаж бүтээл гардаг.

Мөрдөн байцаалтын ажиллагааны явцад эмх цэгц, эрэмбэ дараалал, тактикийн тодорхой төлөвлөгөөгүйгээр ерөнхий хандвал бүтээл гардаггүй.

Төлөвлөгөөний агуулга нь өргөн утгатай ойлголт бөгөөд мөрдөн байцаалтыг эхнээс нь эхэлж дуустал үргэлжүүлэх бүтээлч зохион байгуулалттай үйл ажиллагааны нийлбэр цогц² гэж үздэг.

Мөрдөн байцаалтын төлөвлөгөө нь мөрдөн байцаалт болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тодорхой үе шат бүрт шийдвэрлэвэл зохих зорилт, түүнийг шийдвэрлэх ажиллагааны арга, тактикийг тодорхойлж, хэрэгжүүлэх арга замыг сонгон явуулах ажиллагаа юм.

Мөрдөн байцаалтын төлөвлөгөө нь ажлын ачаалалыг тэнцвэржүүлж

¹ Менежмент. УБ., 2000. 102 дах тал

² Эдийн засгийн гэмт хэрэг мөрдөх аргачлал. УБ., 2010. 182 дахь тал

тухайн хэрэгт хяналт тавих боломжийг хангаж өгөх, үйл ажиллагааг оновчтой болгох, хууль ёсыг зөрчихгүй байх үндсэн нөхцөл болдог.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь хуулиар тогтоогдсон үндэслэл, журмын дагуу явагддаг учраас хариуцлагагүй, анхааралгүй хандвал хуулийг завхруулж, иргэний хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж хохирол учруулах аюулд хүргэдэг.

Гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлэхэд мөрдөн байцаалтын тактикийг сайн бодож боловсруулах, гэмт хэргийн сэжиг, таамаглалыг нэг бүрчлэн нарийг шалган тогтоох хэрэгтэй болдог. Мөрдөн байцаалтын арга, тактик нь мөрдөн байцаалтын ерөнхий болон байцаалтын төлөвлөгөөнд бүрэн тусгагдсан байхыг шаарддаг.

Хэргийн түүвэр төлөвлөгөөг мөрдөн байцаагч хэргийн материалыг эмхэтгэж ангилан цэгцэлсэний дараа ангиллалыг эхнээс нь уншиж товч түүвэр хийнэ.

Хэргийн материалыг нэг бүрчлэн тодорхой судалж ойлгохгүйгээр, мөрдөн байцаалтын ажиллагааг бүрэн дүүрэн шуурхай хийх боломжгүй, ялангуяа хүнд, онц хүнд гэмт хэргийн материалыг ганц уншаад цээжээр мэднэ гэж байхгүй юм.

Мөрдөн байцаалтыг эрхлэн явуулж буй субъект нь олон төрлийн гэмт хэрэг дээр ажилладаг учир мартах, самуурах байдалд орж болох бөгөөд

хэргийн материал нэг бүрийг хэд дахин уншиж судлах, түүвэр, товчлол заавал хийх шаардлага тулгарна.

Практик амьдрал дээр хэргийн түүвэр төлөвлөгөө хийх олон арга хэлбэр байдаг, гэвч дараах зүйлд анхаарал хандуулах нь зүйтэй юм. Үүнд:

1. Нуугдмал үйлдэлтэй, хүнд, онц хүнд, онц их хэмжээний хохиролтой олны анхаарал татсан гэмт хэрэгт он тус бүрээр нь ялган түүвэр хийх

2. Хэд хэдэн этгээд нэг буюу хэд хэдэн гэмт хэргийг хамтран үйлдсэн, эсвэл нэг этгээд хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн ³ яллагдагчтай хэрэгт холбогдогч бүрт чиглэгдэж цугларсан нотлох баримтуудыг тус тус ялган түүвэр хийх

3. Хэргийн талаар онцлог нотлох баримт, гэрчийн мэдүүлэг, яллагдагчийн мэдүүлэг зэргийг он, сар, өдрөөр нь тавьж түүвэр хийх

Хэргийн түүвэр төлөвлөгөө гэдэг нь товчлол хийхийг хэлэх бөгөөд хэргийн нотлох баримт, материалыг хэд дахин судалж ерөнхий болон байцаалтын төлөвлөгөө хийхэд ач холбогдолтой байдаг.

Хавтаст хэргийн дотор байгаа нотлох баримт бүрийг харьцуулан, шинжлэн судлаж, цугларсан материалаар батлагдсан нотлох баримтууд, шалган тогтоох сэжиг, таамаглал бүрийг товчилж түүвэр хийнэ. Харин хэргийн материалын

нотлох баримт, нэг бүрийг сайн судалж товчлол хийчихээд түүндээ найдаж хавтаст хэргийг нотлох баримтыг дахин нягтлан үзэлгүй зөвхөн түүвэр төлөвлөгөөндөө найдан төлөвлөсөн зүйлийхээ биелэлтийг шалгахгүй ажиллавал алдаа дутагдал гарах магадлалтай юм.

Иймээс түүвэр төлөвлөгөө нь мөрдөн байцаагчийн ойлголтыг тодорхой дэс дараалалтай эмх цэгтэй хийх хэргийг тал бүрээс нь бүрэн дүүрэн бодитой тогтооход ач холбогдолтой юм. Мөрдөн байцаалтын ажиллагаа нь цаг хугацааг өрсөж тасралтгүй давшингүй явагддаг тул ямар ч асуудал шинээр тавигдах, үгүйсгэгдэж, батлагдаж байдаг тул тэр бүрийг төлөвлөгөөнд тусгагдсан байхыг шаарддаг онцлогтой.

Мөрдөн байцаалтын хэргийн процессын ажиллагааг хөтлөх тэмдэглэлийг хэрэг бүрт хөтөлнө⁴. Үүнд:

1. Мөрдөн байцаалтын хэрэгт сэжигтэн, яллагдагч, хохирогч, гэрч зэрэг хичнээн хүнээс мэдүүлэг авсан байх

2. Сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авалгүй ямар цаг хугацаа өнгөрч байгаа эсэх

3. Хэзээ эрүүгийн хэрэг үүсгэсэн, хэзээ ямар зүйл ангиар яллагдагчаар

татаж ял сонгосон, сонгосон ялыг өөрчилсөн эсэх

4. Сэжигтэн, яллагдагчийг батлан даалтанд өгсөн, хорьсон, таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж, хүчингүй болгосон хугацаа

5. Хэргийн хугацаа болон хорьж мөрдөх хугацаа хэтэрсэн эсэх

6. Хэрэгт хяналт тавьж байгаа албан тушаалтан

7. Хэргийг шүүхээр шийдвэрлэхээр гаргасан санал

8. Хэрэг ач холбогдол бүхий оролцогч нарын нэр, хаяг, утасны дугаар гэх мэт.

Мөрдөн байцаалтын ерөнхий төлөвлөгөөг дор дурдсаны дагуу хийнэ. Үүнд:

1. Хэргийн түүвэр товчлолыг уншиж шалгах, сэжиг, таамаглалыг тодруулах онцлогууд болон мэдүүлэг нэг бүрийн зөрүүг нэг бүрчилэн шалгаж тэмдэглэж хэзээ яаж шалгахыг төлөвлөгөөнд бичих

2. Хэргийн материалд байгаагүй боловч уг хэргийн талаар хууль ёсоор хийгдвэл зохих зүйлийг төлөвлөгөөнд бичих. Жишээ нь: Тогтоол, ял шийтгэл шалгуулах, шинжилгээ томилох зэрэг

3. Шинээр болон дахин байцаах гэрч, шинжээч, хохирогч, сэжигтэн, яллагдагч

4. Шинээр буюу дахин хийх үзлэг, нэгжлэг, нүүрэлдүүлэн байцаалт, мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагаа, хөрөнгө битүүмжлэх ажиллагаа

³ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. УБ., 2002

⁴ Улсын мөрдөн байцаах газрын даргын 2009 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 17 тоот тушаалын долдугаар хавсралт.

5. Албан байгууллага хүнээс шаардан гаргуулж авах хэргийн холбогдолтой эд зүйлс

6. Хөдөө, орон нутаг, аймаг, хотод байгаа гэрч, хохирогч, яллагдагчийг дуудан ирүүлэх буюу мөрдөн байцаалтын даалгавар бичих

7. Насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэргийн талаар нэмж тогтоовол зохих байдлууд

8. Шинжилгээ заавал хийлгэх⁵

9. Гэмтлийн зэрэг тогтоох

10. Байцаалтанд орчуулагч, хэлмэрч, оролцуулах

11. Гэмт хэргийг үйлдэхдээ ашигласан багаж зэвсэг бусад олдоогүй байгаа нотлох баримтыг цуглуулах, эрэн сурвалжилж олох ажиллагаа

12. Гэмт хэргийн эд мөрийн болон схем, дуу, дүрс бичлэг, гэрэл зургийг авах ажиллагаа

13. Цагаатгах болон яллах нотлох баримтыг шалган үзэх

14. Гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан мэдээ, мэдээллийг шалгуулах, даалгавар, захилга өгөх

15. Шинжлэх техникийн арга ажиллагаа хийх, ул мөр, гарын үсэг, тамга, тэмдэг хуурамч бичиг баримтыг шалгуулах

16. Нягтлан бодох, бусад шинжилгээ томилох тухай зэрэг зайлшгүй хийгдэх асуудлыг төлөвлөгөөнд тусгана.

Байцаалтын төлөвлөгөө нь яллагдагч, гэрч хохирогч, шинжээч болон бусад оролцогчдоос мэдүүлэг авах арга тактикийн асуудлыг дэс дараалалтай боловруулж байгаа хэрэг юм. Ийм учраас байцаалт явуулахын тулд заавал төлөвлөгөө хийнэ.

Мөрдөн байцаагч нь зөвхөн хэргийн материалаар хязгаарлахгүй уг хэргийг юунаас эхлэн яаж шалгах, эхлэж хэнээс мэдүүлэг авах ямар асуултыг ямар дэс дараалалаар асуух, дараагийн мэдүүлэгт ямар асуулт тавих, мэдүүлэг өгч буй хүний хувийн онцлог байдал, хэрхэн хандаж асуулт тавих зэргийг урьдаас бодож боловсруулна.

Ялангуяа нүүрэлдүүлэн байцаахад хэнээр эхлэн яриулах, ямар асуудлыг тодруулах дэлгэрэнгүй буюу зарим зүйлийн талаар нүүрэлдүүлэх тухай урьдаас боловсруулан төлөвлөнө.

Хэргийн болон байцаалтын төлөвлөгөө нь мөрдөн байцаалтын арга, тактикийг боловсруулж байгаа зүйл учраас олон талаар сайн бодож хийх шаардлага тулгардаг байна. Жишээ нь: Цаг хугацаа нь болоогүй асуудлыг эхлээд ил гаргаж тавих юм уу? Цаг хугацаа алдах юм бол асуудлыг хүндрүүлдэг тохиолдол их гардаг байна.

Төрөл садан болон дотны хүмүүс нүүрэлдүүлэн байцаалт өгөх сонирхолгүй, нүүрэлдүүлэн байцаалт өгсөн боловч урьдах мэдүүлэгээсээ буцаж магадгүй, бас зарим хүн өш

⁵ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. УБ.,2002

хонзон санахаас айж нүүрэлдэн байцаалтанд оролцохыг хүсэхгүй байдаг, ийм тохиолдолд мэдүүлгийг дүрс бичлэг, дуу хураагуурийн техник хэрэгслийг ашиглан авах хэрэгтэй юм.

Мөрдөн байцаагч нарын дунд хэргийн түүвэр төлөвлөгөөг хөтлөхөд практик амьдралд дор дурдсан хүндрэлүүд тохиолдож байна⁶. Үүнд:

1. Мөрдөн байцаагч нарын хэргийн түүвэр төлөвлөгөөг 60% нь хүндрэлгүй үйлдэж сурсан байдаг боловч 40% нь хүндрэлтэй байдаг талаар дурдсан байна.

2. Хэргийн түүвэр төлөвлөгөөг ажлын үзүүлэлт төдий байдлаар хэрэгжүүлдэг гэж 70% үзэж байхад 30% нь тийш биш гэж үзэж байна.

3. Шалгах болон түүвэр төлөвлөгөөг 50% агуулгын хувьд ялгаатай гэж үзэж байхад 50% нь адил төсөөтэй гэж үздэг.

4. Түүвэр төлөвлөгөө хийснээр мөрдөн байцаагч нарын ажлын үзүүлэлтэнд 20% нь нөлөөлөл байдаггүй, 30% нь ажил дүгнэх үзүүлэлт болдог, 50% нь түүвэр төлөвлөгөө нь дарга нарт үзүүлэх хэлбэрийн төдий зүйл гэж үзсэн байна.

5. Эрүүгийн хэрэгт 50% нь түүвэр төлөвлөгөөг хийснээр хэрэг шалгах ажиллагаа шуурхай бодитой явагддаг гэж үзэж байхад, 10% нь үгүй, 40% нь зарим талаараа гэж үздэг байна.

ДҮГНЭЛТ

1. Практик амьдралд мөрдөн байцаагч хэргийн түүвэр төлөвлөгөөнд төлөвлөсөн зүйлийхээ биелэлтийг бүрэн дүүрэн биелүүлж чадахгүй болсон шалтгаан нөхцөл түүнийхээ үндэслэлийг бичдэггүй, эсвэл биелэгдсэн тохиолдолд яаж биелэгдсэн талаар дэлгэрэнгүй хөтөлдөггүй, төлөвлөгөөний биелэлтийг “биелэсэн”, “биелээгүй”, он, сар, өдөр, хугацааг тодорхой бус хөтөлдөг явдал нилээдгүй түгээмэл дутагдал байдаг тул зөвлөмж боловсруулж ашиглах

2. Түүвэр төлөвлөгөөг сургалт, үйлдвэрлэл, практикт байнга боловсронгуй болгож байх ямар нэгэн бүтээл, санал шүүмж байхгүй байгаад анхаарал хандуулах.

3. Хэргийн түүвэр төлөвлөгөө хийх загварыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх.

САНАЛ

1. ЦЕГ-ын Мөрдөн байцаах газрын даргын 2009 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 17 тоот тушаалын 7 дугаар хавсралтаар батлагдсан “Эрүүгийн хэргийн түүвэр болон шалгах төлөвлөгөөний загвар нь 2 загвар байх бөгөөд онол, шинжлэх ухааны үндэслэл муутай, амьдралд хөтлөхөд зарим талаараа учир дутагдалтай зүйл ажиглагдаж байгааг анхаарч боловсронгуй болгох

2. Хэргийн түүвэр төлөвлөгөө болон шалгах төлөвлөгөө учир холбогдлыг тайлбарласан загварчлал, стандартыг боловсруулах шаардлага тулгарч байна.

⁶ Мөрдөн байцаах газрын тайлан мэдээ. 2015-2016 оны тайлан.